



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • 07 • № 47

Б.ЛХАГВАСҮРЭН:

МОНГОЛБАНК ЦАР
ТАХЛЫН ХҮНД ҮЕД
ӨӨРИЙН ОРНЫ
ОНЦЛОГ, ЧАДАВХАД
ТУЛГУУРЛАН
ДУНД ХУГАЦААНЫ
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ БОДЛОГО
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

А.АНАНД:

73876 ЗЭЭЛДЭГЧ
ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗЭЭЛИЙН
БҮТЭЦДЭЭ
ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛААД БАЙНА



ЗУРГААН МУТАРТ ГОНГОР

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Ковид-19 цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

2020 оны эхний 6 сарын байдлаар



Эх сурвалж: Монголбанк



04

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ:

ФАТФ-ААС МОНГОЛ
УЛСЫГ ҮЙЛ
АЖИЛЛАГААГАА
ХАНГАЛТТАЙ
БИЕЛҮҮЛСЭН ГЭЖ
ДҮГНЭЛЭЭ



14

НИЙТЛЭЛ

НОГООН
ТАКСОНОМИЙН
АНГИЛАЛ - 3:
ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХЭМНЭЛТТЭЙ
БАРИЛГЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ
НЬ



07

ЯРИЛЦЛАГА:

Б.ЛХАГВАСҮРЭН:
МОНГОЛБАНК ЦАР
ТАХЛЫН ХҮНД
ҮЕД ӨӨРИЙН
ОРНЫ ОНЦЛОГ,
ЧАДАВХАД
ТУЛГУУРЛАН
ДУНД ХУГАЦААНЫ
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ
ХАНГАХ БОДЛОГО
ХЭРЭГЖҮҮЛЖ
БАЙНА



22

ДЭЛХИЙН ЭДИЙН
ЗАСАГ

ХӨГЖИЖ БУЙ УЛС
ОРНУУДЫН ГАДААД
ӨРИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ



20

МОНГОЛБАНК
ЮУ ХИЙДЭГ ВЭ?:

А.АНАНД: 73876
ЗЭЭЛДЭГЧ
ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗЭЭЛИЙН
БҮТЭЦДЭЭ
ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛААД
БАЙНА



26

БАНКИР:

Б.БАЯРМАА:
ЦАР ТАХЛЫН ҮЕД
ХАРИЛЦАГЧДАА
БҮХ ТАЛААР
ДЭМЖИН
АЖИЛЛАЖ БАЙНА



30

СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭ

МОНГОЛ
УЛСЫН ЭДИЙН
ЗАСГИЙН ӨСӨЛТ,
ЭКСПОРТЫН
ЦААШДЫН
ТӨЛӨВ

2020 ОНЫ 7 ДУГААР САРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2020.07.01

**ФАТФ-ААС МОНГОЛ УЛСЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХАНГАЛТТАЙ
БИЕЛҮҮЛСЭН ГЭЖ ДҮГНЭЛЭЭ**

"Монгол улс ФАТФ-ын стратегийн дутагдалтай улсуудын жагсаалтаас гарахтай холбоотой төрийн болон мэргэжлийн холбоодын тасралтгүй хамтын ажиллагааны үр дүнд 2019 оны 10 дугаар сард ФАТФ-аас өгөгдсөн 6 үүрэг даалгаврыг амжилттай биелүүлээ. Уг үр дүнг ФАТФ-ын цахим хуудсанд 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр нийтэлсэн бөгөөд албан

бус орчуулгыг хүргэж байна."

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын хяналтад байгаа улс орнууд мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдлаа арилгах зорилгоор идэвхтэй хамтран ажиллаж байна. ФАТФ-аас улс орнуудыг хяналтад оруулсан гэдэг нь тухайн улс орнуудыг стратегийн дутагдлаа тогтоосон хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэх үүрэг амлалт өгч, хяналтад хамруулахыг хэлдэг. Энэхүү хяналтын жагсаалтыг ихэвчлэн "саарал жагсаалт" гэж нэрлэдэг. ФАТФ-ын зүгээс хяналтад байгаа улс орнууддаа стратегийн дутагдлаа шийдвэрлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийн талаарх тайланг ирүүлэх, харилцан тохиролцсон үйл ажиллагааны төлөвлөгөөгөө заасан хугацаанд яаралтай биелүүлж дуусгахыг шаарддаг. Хэдийгээр ФАТФ нь эдгээр улс орнуудад харилцагчдыг таньж мэдэх нарийвчилсан хяналтын арга хэмжээ авахыг шаарддаггүй боловч өөрийн гишүүн орнуудыг тухайн улс орнуудын эрсдэлийг үнэлсэн мэдээллийг анхаарч үзэхийг зөвлөж байна. Мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудыг нэмж тодорхойлох ажлыг цаашид үргэлжлүүлэх болно. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ФАТФ-аас хяналтын жагсаалтад багтсан улс орнуудад үнэлгээ хийх ажлыг 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр түр зогсоохоор шийдвэрлэсэн. Харин Монгол Улсын хүсэлтийг харгалзан үзэж, үнэлгээ хийх хугацааг хойшлуулахгүйгээр хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн бөгөөд бусад улс орнуудад хийх үнэлгээний хугацааг 4 сараар сунгалаа. Үүний үр дүнд ФАТФ-аас Монгол Улсын үнэлгээг хийж, холбогдох төлөөллүүдтэй цахим хурал зохион байгуулсан бөгөөд энэхүү хурлын үр дүнг танилцуулж байна.

Монгол Улс

2019 оны 10 дугаар сард Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэх, холбогдох техникийн дутагдлыг арилгах чиглэлээр ФАТФ болон Ази, Номхон далайн хамтарсан бүлэгтэй хамтран ажиллах улс төрийн өндөр түвшний үүрэг амлалтыг өгсөн. Энэ хүрээнд ФАТФ-ын 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн онлайн хурлаар Монгол Улсыг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хангалттай биелүүлсэн гэж дүгнэлээ. Түүнчлэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнгийн хэрэгжилтийг үнэлэх, цаашид хэрэгжилтийг тогтвортой хангахын тулд улс төрөөс шаардагдах хүчин чармайлт байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор газар дээрх хяналт шалгалт хийх шийдвэрийг гаргав.

Монгол Улс дараах гол шинэчлэлүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- (1) Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулах;
- (2) тодорхойлсон эрсдэлтэй нь уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, прокурорын түвшинд ялах ажиллагааг нэмэгдүүлэх;
- (3) хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх,

- гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах;
- (4) хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах;
 - (5) санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйлдвэрлэл хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах зэрэг юм. ФАТФ-аас Ковид-19 цар тахлын нөхцөл байдлыг харгалзан үзэж, Монгол Улсад газар дээрх хяналт шалгалтыг хамгийн боломжит ойрын хугацаанд хийхээр шийдвэрлэлээ.

Иймд ФАТФ-аас 2020 оны 2 дугаар сард гаргасан хяналтын жагсаалтад Монгол Улс болон Исланд Улсаас бусад дараах улс орнуудыг хэвээр үлдээж байна. Үүнд:

- | | | |
|-------------------|---------------|--------------|
| 1. Албани | 7. Ямаик | 13. Сири |
| 2. Багамын арлууд | 8. Мавритани | 14. Уганда |
| 3. Барбадос | 9. Мьянмар | 15. Йемен |
| 4. Ботсвана | 10. Никарагуа | 16. Зимбабве |
| 5. Камбож | 11. Пакистан | |
| 6. Гана | 12. Панам | |

2020.07.02

НОГООН ЗЭЭЛИЙН СТАТИСТИКИЙГ ГАРГАН, МЭДЭЭЛЭХЭЭР БОЛОО



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр Монгол Улсад мөрдөгдөх "Ногоон таксономи" батлагдсантай холбогдуулан Ногоон зээлийн статистик мэдээллийг банкуудаас авч нэгтгэн, урьдчилсан байдлаар олон нийтэд зарлаж байхаар боллоо.

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар арилжааны банкуудаас олгосон нийт зээлийн үлдэгдэл 16,988.9 тэрбум төгрөг байгаагийн 428.1 тэрбум төгрөг буюу 2.5%-ийг ногоон зээл бүрдүүлж байна. Ногоон зээлийн үлдэгдэл тайлант улиралд өмнөх улирлаас 5.2%-иар буурчээ. Хувийн байгууллагуудын ногоон зээлийн үлдэгдлийн 35.1% буюу 130.5 тэрбум төгрөгийг тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал, 29.6% буюу 110.2 тэрбум төгрөгийг ногоон барилга, 14.4% буюу 53.5 тэрбум төгрөгийг тогтвортой ус, хаягдлын хэрэглээ, 11.0% буюу 40.8 тэрбум төгрөгийг эрчим хүчний хэмнэлт, 5.4% буюу 20.0 тэрбум төгрөгийг сэргээгдэх эрчим хүчний төсөл, хөтөлбөрүүд эзэлж байна.

2020.07.08

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭГЧ БАГШ НАРТ ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЛЭЭ



Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, БСШУЯ хамтран "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 2016-2021 онд хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд санхүүгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд мэргэжилтнүүд болон сургагч багш нарын тусламжтайгаар Монгол Улсын хэмжээнд Насан туршийн боловсролын үндэсний төв, Хүүхэд залуучуудын төв, МСҮТ, их дээд сургуулиуд болон ЕБС-ийн нийт 2,376 багшийг бэлтгэсэн байна. Энэхүү үр дүнтэй байдлыг харгалзан үзэж сургагч багш нар болон хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагын мэргэжилтнүүдэд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г. Энхтайван талархал илэрхийлэв. Мөн үеэр Монголбанк, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв болон Бичил Санхүүгийн хөгжлийн сантай хамтран 2019 оны "Санхүүгийн шилдэг сургагч багш" нарыг тодрууллаа.

2020.07.05

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД МОНГОЛБАНКНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОВХИМОЛ ГАРЛАА



“КОВИД-19” цар тахлын үед Монголбанкнаас хэд хэдэн багц арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх танилцуулга, материалуудыг нэгтгэж, нийтэд хүргэж байна. “КОВИД-19” цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ сэдэвт тус товхимолд 2020 оны эхний хагаст хэрэгжүүлж гүйцэтгэсэн 13 ажлыг онцлон мэдээлэв. Үүнд банкуудын хөрвөх чадвартай хөрөнгийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн өртгийг бууруулах, санхүүгийн зуучлал тогтвортой үргэлжлэх нөхцөлийг дэмжих арга хэмжээнүүд, мөн иргэд, аж ахуйн нэгжид тулгарч буй дарамтыг бууруулах, төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг түр хойшлуулах зэрэг шийдвэрүүд багтжээ.

2020.07.20

“НЯГТЛАХ ТУСАМ АЮУЛГҮЙ” АЯНЫГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ



Монголбанк, ХААН банк, Цагдаагийн Ерөнхий Газар (ЦЕГ)-тай хамтран “Нягтлах тусам аюулгүй” аяныг 2020 оны 4 дүгээр сарын 20-ноос 6 дугаар сарын 20-ныг дуустал хугацаанд улс орон даяар амжилттай хэрэгжүүллээ. Монгол Улсын хэмжээнд эрүүгийн хуулийн 17.3-д заасан “Залилах” гэмт хэрэг 2018 онд 5372 удаа бүртгэгдэж байсан бол 2019 онд энэ тоо 7821 болж өссөн бөгөөд гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад учирсан хохирлын хэмжээ 165.6 тэрбум төгрөгт хүрч өсөөд байсан юм.

Иймд ЦЕГ-аас Монголбанк, Монголын банкны холбоотой хамтран олон нийтэд нөлөөлөх цуврал аяныг хэрэгжүүлснээр гэмт хэргийн тоо 2020 оны эхний 6 сарын байдлаар 2598 болж, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 52.8 тэрбум төгрөг болж, буураад байна. Монголбанк, Монголын банкны холбоо, ЦЕГ-ын Мөрдөн байцаах алба хамтарч залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ оны нэгдүгээр сард “Ятгах тусам нягтал” аяныг нэг сарын хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд уг аяны үргэлжлэл болгон “Нягтлах тусам аюулгүй” аяныг зохион байгуулсан юм.

2020.07.29

“SWAROVSKI” ШИГТГЭЭТЭЙ “ХУЛГАНА ЖИЛ” ЗООС ХУДАЛДААНД ГАРЛАА



“Арван хоёр жил” цувралыг шинээр эхлүүлж “Хулгана жил” зоос худалдаанд гаргаж эхэлсэн ба тус мөнгөн зоос нь 31.1 гр жинтэй, 38.61 мм диаметртэй бөгөөд зоосны хамгийн сүүлийн үеийн технологиор бүтээгдэж, Монгол ардын магтаалыг тусган эрдэнийн зүйлийг Swarovski шигтгээгээр төлөөлүүлж хийв. Түүнчлэн дурсгалын зоосны төрөлд 1 унц болон 1 кг мөнгөн гулдмайнууд, 4 кг үрлэн мөнгийг Монголбанкнаас худалдан авах боломжтой боллоо.



Б.ЛХАГВАСҮРЭН: МОНГОЛБАНК ЦАР ТАХЛЫН ХҮНД ҮЕД ӨӨРИЙН ОРНЫ ОНЦЛОГ, ЧАДАВХАД ТУЛГУУРЛАН ДУНД ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнтэй ярилцлаа.

Эдийн засгийн нөхцөл байдал ямар байна вэ? Нөхцөл байдлыг Төв банк хэрхэн харж, дүгнэж байна вэ?

Товчхондоо дэлхийн эдийн засаг 4-5 хувиар агшиж байхад манай эдийн засаг эерэг өсөлттэй байх боломжгүй. Ойрын ирээдүйн тодорхой бус байдал бүр өндөр байна. Сүүлийн Мөнгөний бодлогын хорооны хурлаар мөнгөний бодлогын төлөвийг хэлэлцэж байхдаа эдийн засгийн өсөлт II улиралд -7% орчим, жилийн дүнгээрээ -1% байх төсөөлөл хийж ярилцсан. Бусад олон улсын байгууллагууд ч бас иймэрхүү төсөөлөлтэй байх шиг байна.

Эдийн засгийг өнөөдөр дэмжих нь чухал ч ирээдүйд ямар ч нөхцөл байдал үүсч болзошгүй байгаа тул өрх, бизнес, төр гээд бүх л түвшинд

санхүүгийн нөөцөө гамнах нь бүр илүү чухал байна. Өөрөөр хэлбэл, цаашид эдийн засгийг сэргээх гэхээсээ илүүтэй тогтворжуулах шаардлага үүсч болзошгүй. Иймд Монголбанкны зүгээс иргэд, бизнест учирч буй өнөөгийн хүндрэлтэй нөхцөлийг зөөллөх, гэхдээ бодлогын орон зайгаа гамнах, дунд хугацааны тогтвортой байдалд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Мэдээж олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, бусад Төв банкуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг харгалзан үзэж судлан өөрийн орны онцлогт тохирсон мөнгөний бодлогын цогц арга хэмжээг тухай бүрт нь авч хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээ нь эдийн засгийг богино, дунд хугацаанд дэмжих,

санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэж байгаа. Гэвч гадаад орчин буюу улс орнууд КОВИД-19 вирусийг хэдий хугацаанд хяналтдаа оруулах, том гүрнүүдийн гадаад худалдааны маргаан хэрхэн үргэлжлэх, гадаад эрэлт, эрдэс бүтээгдэхүүний үнэд хэр хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх зэрэг нь манай эдийн засагт эрсдэлийг нэмэгдүүлсээр байна.

Мөнгөний бодлогын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа гэлээ. Мөнгөний бодлогын ямар шийдвэрүүдийг гаргасан бэ? Шийдвэр гаргах болсон гол үндэслэл юу байв?

Он гарснаас хойш Мөнгөний Бодлогын Хороо ээлжит болон ээлжит бусаар 3 удаа хуралдаж эдийн засаг, банк, санхүүгийн салбарт үүсч буй, үүсч болзошгүй хүндрэлийг зөөлрүүлэх зорилгоор урьдчилан шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах зорилгоор 3 болон 4-р сард бодлогын хүүг нийт 2 нэгж хувиар буурууллаа. Мөн банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, илүү бага хүүгээр Төв банкнаас репо санхүүжилт авах бололцоог бий болгох шаардлага үүссэн учраас Төв банкны хүүний коридорыг 1 нэгж хувиар нарийсгаад байна. Ингэснээр Төв банкнаас банкууд 13%-иар санхүүжилт авдаг байсан бол бодлогын хүүний бууралт болон хүүний коридорын өөрчлөлтийн нөлөөгөөр одоо 10 хувийн хүүгээр санхүүжилт авч байна.

Мөн Төв банкны хүүнээс гадна төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5%-иас 8.5% болгосон нь 320 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөгдөж, банкны эх үүсвэрийн алдагдсан боломжийн өртөг буурах, улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүүг бууруулах арга хэмжээ болсон юм. Хөнгөлттэй хүүтэй орон сууцны ипотекийн хөтөлбөрийг дахин эхлүүлсэн, Засгийн газрын алт хөтөлбөрийг дэмжин эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авсны үр дүнд алт олборлолт болон Төв банкинд тушаалт мэдэгдэхүйц нэмэгдлээ.

Эдийн засагт бизнесийн идэвхжил муудаж, иргэд санхүүгийн хүнд нөхцөлд байна. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

Хэд хэдэн зүйлийг ойлгох хэрэгтэй байна. Нэгд, иргэдийн орлого нь эдийн засгийн өсөлттэй шууд холбоотой. Хоёрт, иргэн зээл авахдаа, банк зээл олгохдоо ирээдүйн орлогын тогтвортой байдлаа аль болох зөв үнэлсний үндсэн дээр зээлийн хэмжээгээ зохистой түвшинд тодорхойлж байх шаардлагатайг өнөөгийн нөхцөл байдал ойлгуулж байна.

зээлийн эргэн төлөлт доголдоно гэдэг нь тухайн зээлдүүлэгч өөрийн харилцагч банкны тогтвортой байдал, цаашилбал нийт санхүүгийн системийн тогтвортой байдалтай холбогддог. иймд эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчдийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар, ипотекийн зээлийн хугацааг 6 сараар сунгах шийдвэр гаргаад хэрэгжүүлж байна. үүний үр дүнд зээлдэгчдийн зээлийн сарын төлбөрийн хэмжээ буурч гар дээр үлдэх орлого нэмэгдсэн.

Ингэснээр зээл доголдохоос сэргийлэхийн зэрэгцээ өрхийн хэрэглээ огцом буурахаас сэргийлж байгаа юм. 6 дугаар сарын 19-ний байдлаар нийт хэрэглээний зээлийн багцын 12.9% буюу 65491 зээлдэгчийн 572.8 тэрбум төгрөгийн хэрэглээний зээл, ипотекийн зээлийн 43% буюу 38270 зээлдэгчийн 2.0 их наяд төгрөгийн зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон.

Бизнесийн хувьд борлуулалт буурч, зээлээ төлж чадахгүй нөхцөл үүсч байна уу?

Бизнесийн байгууллагууд ялангуяа санхүүгийн хөшүүрэг нь хэт өндөр болсон зээлдэгчид борлуулалтын орлого агших үед санхүүгийн дарамтад ордог. Бидний хийсэн судалгаагаар 2020 оны 6 сарын 19-ний байдлаар бизнесийн зээлийн 37% нь Ковид-19-т өртсөн байдалтай гарсан. Энэ нөхцөл байдлыг урьдчилан зөөлрүүлэх үүднээс Ковидын нөлөөнд автсан зээлүүдийн хувьд хэвийн ангилалд хэвээр үргэлжлүүлэх хугацааг 15-аас 90 хоног болгох, бүтэц өөрчлөгдсөн тохиолдолд бүтэц өөрчлөгдсөн зээлд ангилахгүй байх, хэрэглээний зээлийн 2020.1.31-ны байдлаарх чанарын ангиллыг хэвээр мөрдөх зэрэг шийдвэрийг Санхүүгийн тогтвортой

байдлын зөвлөлд танилцуулан хэрэгжүүлж эхэлснийг санаж байгаа байх. Ингэснээр Ковидын нөлөөнд автсан зээлийн 39%-д нь бүтцийн өөрчлөлт хийж, эргэн төлөлтийн хөнгөлөлт үзүүлсэн гэсэн статистик үзүүлэлт байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсаар байна. Энэ хүрээнд бодлогын ямар арга хэмжээнүүд авч байна вэ?

Тийм ээ, таны хэлсэнчлэн төгрөг ам.долларын эсрэг оны эхнээс 3 хувь сулраад байна. Харин эхний 6 сарын байдлаар юанийн эсрэг 1.8%-иар суларсан бол рублийн эсрэг 9.1% чангараад байна. Гадаад худалдааны сагсаар жигнэсэн дундаж ханш буюу бодит болон нэрлэсэн үйлчилж буй ханш оны эхнээс харгалзан 3% болон 1%-иар тус тус чангарсан байна. Тиймээс ам.долларын эсрэг 3 хувийн сулралт бол зайлшгүй байсан гэсэн үг. Нөгөө талаас экспортын орлого эхний 5 сарын байдлаар 39%-иар тасарсан үед тодорхой хэмжээний ханшийн тохируулга байх ёстой. Энэ нь дунд хугацааны тогтвортой байдалд эрсдэл хуримтлуулахгүй байхад тустай. Энэ жилийн хувьд алт худалдан авалт их сайн байгаа. Эхний 6 сарын байдлаар өнгөрсөн оны түвшнээс 2.5 дахин их буюу 10.8 тонн алт худалдан авсан нь валютын урсгалд том дэмжлэг болж байна.

Түүнээс гадна Монголбанкнаас макро зохистой бодлогын хүрээнд долларжилтын эсрэг зөөлнөөс нь эхлүүлээд арга хэмжээнүүдийг тасралтгүй авч байна. Тухайлбал, төгрөгийн заавал байлгах нөөцийг гадаад валютынхаас бараг 2 дахин бага түвшинд хүргэсэн, гадаад валютын харилцахдаа хүү төлж байгаа, гадаад валютын хадгаламждаа өндөр хүү төлж байгаа банкуудын төгрөгийн ЗБН-ийн урамшууллыг хорогдуулах, зөвхөн төгрөгөөр төлбөр тооцоо хийх зэрэг арга хэмжээнүүдийг зэрэгцүүлэн аваад байна.

ЦААШИД Ч ХӨРВӨЛТИЙГ СААРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН АВНА. ИРГЭД, ОЛОН НИЙТ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ ТӨГРӨГТӨӨ ИЛҮҮ ИТГЭЖ ТӨВ БАНКНЫ БОДЛОГЫГ ДЭМЖВЭЛ ҮР ДҮНД ХУРДАН ХҮРЧ ТӨВ БАНКНЫ ХУВЬД БОДЛОГЫН ОРОН ЗАЙ ҮҮСЭХ БОЛНО.

Банкуудад зээлийн эх үүсвэр хангалттай байж чадаж байна уу? Монголбанкны зүгээс банкуудад эх үүсвэр нийлүүлэх бололцоо бий юү?

Ковидын үед банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагыг 25%-иас 20% болгож бууруулсан бөгөөд уг үзүүлэлт системийн хэмжээнд 39.7%-тай байна. Өмнө нь дурдсанчлан Төв банкны санхүүжилтийн хүү 10% болж, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн дийлэнхийг бүрдүүлдэг хадгаламжийн хүүнээс бага болсон. Түүнээс гадна санхүүгийн зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хадгалах, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор оны эхний 6 сарын байдлаар ХХБ-ны 500 сая ам.долларын эргэн төлөлтийг эс тооцвол Монголбанкнаас банкуудад 3.9 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон бол үүний 2.4 их наядыг репо санхүүжилтээр, 1.5 их наядыг своп хэлцлээр олгоод байна.

Түүнчлэн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, хугацааг сунгах зэрэг арга хэмжээ нь зээлдэгч талдаа дэмжлэг болохын зэрэгцээ зээл чанаргүйдсэнээс бий болох эрсдэлийн сангийн зардлын дарамтыг бууруулж байгаа нь банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээнд дэмжлэг болдог. Энэ нь зээлийн тасалдлыг зөөлрүүлэхэд ч эерэгээр нөлөөлнө. Болзошгүй эрсдэлээс сэргийлэн банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын түр зуурын хүндрэлийг шийдвэрлэх зорилготой барьцаат зээлийн нөхцөлийг өөрчлөөд мөрдүүлж эхлээд байна. Өмнө нь Төв банкны мөнгөний бодлого болгоомжтой хатуу төлөвтэй байсан бол одоо бодлогын төлөв илүү зөөлөрсөн, бодлогын олон арга хэмжээнүүдийг хооронд нь нийцтэй байдлаар багц маягаар авч хэрэгжүүлж байна.

Эдийн засгийн өнөөгийн хүнд нөхцөлд улс орнуудад эрсдэл хуримтлагдаж, зээлжих зэрэглэл нь буурч байгаа. Монгол Улсын хувьд нөхцөл байдал хэр байна вэ?

Зээлжих зэрэглэл харьцангуй тогтвортой байгаа нь Монгол улсад хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь шийдлээ, цагаа олсон байгааг мөн гадаад, дотоод хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалж, гадаад зээлийн хүүний болон үндсэн төлбөрийг

эргэн төлөх чадвартайг харуулж байна гэж Төв банкны зүгээс харж байгаа. Монголбанк, Сангийн яам хамтран олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагтай 3 болон 5-р сард, Мүүдис агентлагтай 4 дүгээр сард, Эс энд Пи агентлагтай 6 дугаар сард цахим уулзалт зохион байгуулж шаардлагтай мэдээллүүдийг өгсөн, байр сууриа тодорхой илэрхийлсэн, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний зорилго, онцлогыг тайлбарласан. Фитч болон Эс энд Пи агентлагаас 2020 оны 5, 6 дугаар сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр, төлөвийг “Тогтвортой” хэвээр үнэлсэн байгаа. Эдгээр хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт нь хорио цээрийн дэглэмийн энэ хүнд үед бодлого шийдвэрүүд нийцтэй, хүндрэлийг давах боломжтойг харуулсан үнэлгээ юм. Бас нэг онцлох зүйл нь Монгол Улс Олон Улсын Валютын Сантай хамтын харилцаагаа хадгалж байгаа нь гадны хөрөнгө оруулагчдад эерэг дохио өгч байгаа гэж бидний зүгээс харж байна.



ТА БҮХНИЙ МЭДЭЖ БАЙГААГААР ТӨСӨВ БОЛОН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛБАНК ХЭЛЭЛЦЭЭРТ ОРЖ ОУВС-ИЙН ШУУРХАЙ САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАН 99 САЯ АМ.ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТИЙГ АВААД БАЙНА.



Энэхүү хөтөлбөр нь ОУВС-тай өнгөрсөн 3 жилийн хугацаанд хамтран хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлж, дараагийн хөтөлбөр буюу “Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр”-т шилжээд байгааг илэрхийлж байгаа юм.



ФАТФ-аас Монгол Улсыг өгсөн үүрэг даалгаврыг сайн биелүүлсэн гэж онцолсон байсан. Энэ талаар мэдээлэл өгнө үү?

Энэ нь бидний хувьд богино хугацаанд хийж чадсан чамлахааргүй амжилт болсон гэж үзэж байна. Монгол Улс ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад 2019 оны 10 дугаар сард орсон ба нийт 6 үүрэг даалгавар бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр болсон. Эхний явцын тайланг 2020 оны 1 дүгээр

сард БНХАУ-д зохион байгуулсан хурлаар хэлэлцүүлж, ФАТФ-ын 2 дугаар сарын хурлаар тохирсон ажлын 50 хувьд нь хангалттай гэсэн үнэлгээ авсан. Харин КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор ФАТФ-аас хяналтын жагсаалтад багтсан бүх улс оронд үнэлгээ хийх ажлыг 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр түр зогсоож, 4 сараар хойшлуулахаар шийдвэрлэсэн. Гэхдээ Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын хүсэлтээр Монгол Улсын үнэлгээ хийх хугацааг хойшлуулахгүйгээр хэвээр үлдээж, 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр тайлангаа цахимаар танилцуулж, амжилттай хамгаалаад байна.

Үүний үр дүнд ФАТФ-ын 2020 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар Монгол Улсыг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хангалттай биелүүлсэн гэж дүгнэсэнд баяртай байна. Сонирхуулж хэлэхэд ФАТФ-ын хяналтын жагсаалтанд 2009 оноос хойш нийт 51 улс орон орж байсан бөгөөд дунджаар 3 жил 2 сарын хугацаанд ФАТФ-тай тохиролцсон ажлын төлөвлөгөөгөө хангалттай биелүүлж, газар дээрх хяналт шалгалт хийлгэхээр болсон байдаг. Харин Монгол Улсын хувьд 2019 оны 10 дугаар сараас хойш нийт 7 сарын хугацаанд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хангалттай биелүүлсэн хэмээн үнэлүүлээд байна.

Ярилцсанд баярлалаа.

ЗУРГААН МУТАРТ ГОНГОР



Санскрит: Махагал | Түвэд: Гонгор | XX зуун Мөнгө хөөмөл
Жин: 1435 гр | Өндөр: 33 см, суурь: 12 x 10.5 см

1995 онд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн II хорооны иргэн Л.Дунгармаагаас Монголбанкны Эрдэнэсийн санд худалдан авчээ. Цагаан Гонгор бурхан нь ялимгүй догшин, нэг нүүрт, зургаан мутартай бөгөөд дундах баруун, зүүн мутрын эхэнд хүсэл хангагч зэндмэнэ эрдэнэ, эрдэнээр дүүрэн гавал бумба, дээд баруун зүүн мутартаа ядуу хоосныг арилгагч /Дорждигүг/ гурван ертөнцийг сүрээр дарагч гурван үзүүрт сэрээ, доод талын баруун, зүүн мутартаа данигасыг дуудах /Жанджвү/ хонх дамар, сансар нирвааныг эрхэнд татагч гох дэгээг тус тус барьсан барьцтай. Гонгор саад тотгорыг арилгахаас гадна эд хөрөнгийг арвижуулагч бурхан хэмээн эрхэмлэн шүтэгдсээр иржээ.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ


2020 оны 6 дугаар сарын статистик мэдээллийн тойм

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)




Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)




- М2 мөнгөний жилийн өсөлт 5.5% болж, 21.3 их наяд төгрөгт хүрэв. Жилийн өсөлтийн 7.0 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.6 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 0.5 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -2.8 нэгж хувийг төгрөгийн харилцах бүрдүүлсэн байна.
- М2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.5 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 2.9 их наяд төгрөгтэй тус тус тэнцж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор




Зураг 2.2. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл 17.2 их наяд төгрөг (төгрөгийн зээл 15.6 их наяд, гадаад валютын зээл 1.6 их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас 1.1%-иар
- Хэвийн зээл өмнөх сараас 2.7%-иар тус тус өсч,
- Чанаргүй зээл өмнөх сараас 2.7%-иар
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 12.2%-иар буурсан байна.

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.2. Ипотекийн зээлийн чанарын үзүүлэлт




- 98.4 мянган эзэлдэгчийн 4.7 их наяд төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Ипотекийн нийт зээлийн үлдэгдлийн 73.8% нь хөтөлбөрийн хүрээнд, 21.9% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 4.3% нь бусад эх үүсвэрээр олгогджээ.
- Орон нутгийн ипотекийн зээл*-ийн 76.3% нь хөтөлбөрийн зээл, 21.3% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.4% нь бусад эх үүсвэрээр олгогджээ.
- Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.3 хувь нь хэвийн, 1.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.9 хувь нь чанаргүй зээл байна.
- Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 51.1 хувийг хөтөлбөрийн зээл, 47.9 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.0 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.


*Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршилгаар тооцсон.

4. Хүү

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү




Зураг 4.2. Нийт шинээр олгосон зээл, хүү




- 2020 оны 6 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 10.0 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.3 хувь байна. Төгрөгийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурчээ.
- Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.3 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.3 хувьд болж, шинээр олгосон төгрөгийн зээл өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

*Хотолборийн тээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.




5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны эхний 5 сар /урьдчилсан/



5.1. Гадаад өрийн статистик, 2020 оны I улирал



	2019.IV	2020.I	Өөрчлөлт
Засгийн газар	7,806	7,236	-570
Зээл	4,683	4,748	65
Бонд, өрийн бичиг	3,123	2,488	-635



НОГООН ТАКСОНОМИЙН АНГИЛАЛ-3

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ БАРИЛГЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ НЬ

Монгол Улсын Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Ногоон таксономийг баталсан билээ. Ингэснээр дэлхийд Ногоон таксономи баталсан 2 дахь улс болсон бөгөөд 6 дугаар сард гарсан Дэлхийн банкны Ногоон таксономи боловсруулах заавар, гарын авлага эрхлэн гаргасны сайн туршлагын нэгээр дурдсан байна. Тус таксономи нь 8 салбарын 58 үйл ажиллагааг ногоон үйл ажиллагаа хэмээн тодорхойлсон.

Монголбанкны мэдээлэл сэтгүүлд Ногоон таксономийг олон нийтэд таниулах зорилгоор цуврал нийтлэл гаргаж байгаа бөгөөд энэ удаагийн дугаарт 3 дахь салбар буюу Эрчим хүчний хэмнэлтийн салбарыг онцолж байна.

Та 10 жилийн дараах Улаанбаатарыг хэрхэн төсөөлдөг вэ? Улаанбаатар хотын талаас их нутаг дэвсгэрийг эзэлдэг гэр хорооллын бүс нийтдээ үгүй болж орон сууцны хороолол болох болов уу? Эсвэл олон улсын туршлагаар түрэгдэн тусгаарлагдаж тусдаа хороолол болон баян ядуугийн зөрүүг улам лавшруулах болов уу? Гэр хороолол, дэд бүтэцгүй байдагтай холбоотой орчны бохирдлын асуудлууд үргэлжилсээр байх уу? Эсвэл бахь байдгаараа байх юм болов уу?

Бидний төсөөлж буй Улаанбаатар 2030 онд гэр хорооллын талбайн тал хувь нь нийтийн эсвэл амины орон сууцны хороололоор солигдсон, үлдсэн сууц, гэрүүд дулаалга бүхий хот байна.

Барилгын үйлдвэрлэл Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлын 5 хувийг эзэлдэг боловч, нийт дулааны эрчим хүчний 56 хувь, цахилгаан эрчим хүчний 38 хувийг тус тус хэрэглэж, Монгол Улсын хүлэмжийн хийн 49.4%-ийг ялгаруулдаг эрчим хүчний салбарын томоохон хэрэглэгч юм. Хэрэв бид Парисын хэлэлцээрт хүлээсэн амлалтынхаа хүрээнд ялгаруулахаар төлөвлөж буй хүлэмжийн хийн 22.7%-ийг бууруулна гэж үзвэл i) одоо байгаа барилгуудад дулаалга хийх, ii) шинээр баригдаж буй барилгуудыг эрчим хүчний хэмнэлттэй барих зэрэг дорвитой ажлыг хийснээр 2030 он гэхэд үр дүндээ амжилттай хүрнэ гэж харж болох юм. Өөрөөр хэлбэл, эрчим хүчний хэмнэлттэй барилгыг дэмжсэнээр амлалтдаа маш ойртож очих боломж бий. Тухайлбал, гэр хорооллын хувийн сууцуудын эрчим хүчний үр ашгийн үзүүлэлт дулааны стандарт нормоос 2.6

дахин, угсармал орон сууц 2 дахин, төсвийн санхүүжилттэй байгууллагын хувьд 1.7 дахин хүртэл доогуур байна. Улаанбаатар хотын гэр хорооллын амины сууцны 10 хувь нь л барилгын норм, стандартын шаардлагад нийцсэн бөгөөд Дэлхийн банкны “Цэвэр Агаар” төслийн судалгаагаар эдгээр амины сууцыг дулаалснаар дулаан алдагдлыг дунджаар 50 хувиар бууруулах боломжтой гэжээ. Мэдээж Улаанбаатар хотын хүн ам огцом өсөхийн хэрээр анхдагч хэрэгцээ болох орон сууцны асуудал хүндээр тавигдах бөгөөд олон улсад ч барилгын эрчим хүч жил бүр 1 хувиар өсөх хандлага ажиглагдаж байна. Нийслэлийн Орон Сууцны Корпорацийн 2019 оны судалгаагаар Улаанбаатар хотын нийт айл өрхийн 64% нь буюу 290,232 айл өрх ойрын 3 жилдээ инженерийн дэд бүтэц бүхий орон сууцтай болох хэрэгцээтэй гэдгээ илэрхийлсэн. Харин одоо бэлэн байгаа, дараагийн 3 жилд хэрэгжих орон сууцны төслүүдийг нийт эрэлттэй харьцуулж үзвэл ойрын 3 жилд 11,651 орон сууцны эрэлтийн илүүдэл байгаа боловч худалдан авах нийт эрэлтийн 83% буюу 42,881 өрх нь орон сууцны эзэлд хамрагдах шаардлагатай санхүүгийн

нөхцөл байдалтай байна. Иймээс орон сууцны урт хугацааны хөнгөлөлттэй эх үүсвэр, (эрчим хүчний хэмнэлт, ногоон бүтээгдэхүүнд зориулан олгож буй олон улсын хөнгөлөлттэй эх үүсвэр)-ийг бүрдүүлж, эрчим хүчний хэмнэлтийг санхүүжүүлэх шаардлагатай юм.

Орон сууц авахдаа асууж сурах, анхаарах ёстой асуулт: "Миний байр хэд иддэг вэ?"

Ногоон таксономийн 3 дугаар салбар болох Эрчим хүчний хэмнэлтийн 3.3-т шинэ эрчим хүчний хэмнэлттэй барилга барих, баригдсан сууцны дулаалгын ажлыг дурдсан байна. Тэгвэл эрчим хүчний хэмнэлттэй барилга гэж юу вэ?

Монголд барилгын дулаан хамгаалалтын норм "БНБД 23-02-09"-д барилгын 1 жилийн турш 1 нэгж талбайд ашиглах дулааныг нь тооцоолон гарч ирэх аргачлалыг заасан байна. Тус тооцооллоор байшинд эрчим хүчний паспорт өгөх бөгөөд хамгийн хэмнэлттэй байшинд "АА" буюу ногоон паспорт, хамгийн хэрэглээ ихтэйд "Е" буюу хүрэн паспорт өгөх юм. Эрчим хүчний хэмнэлттэй тусмаа дулааны алдагдал багатай байх бөгөөд дулаан бага зарцуулж, ашиглалтын зардал бага гарах юм. Хялбараар тайлбарлавал, анх машин авахдаа бид "100-д хэд иддэг вэ?" гэж асуудагтай адил эрчим хүчний паспорт нэвтэрсэн, эрчим хүч үнэтэй Европын орнуудад "миний байшин/байр хэд иддэг вэ" гэдэг түгээмэл асуулт байна.

Эрчим хүчний хэмнэлттэй барилгын санхүүжилт бол боломж.

Эрчим хүчний хэмнэлтийг бий болгоход эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн бөгөөд барилгын салбар төдийгүй санхүүгийн байгууллагууд идэвхийлэн ажиллаж байна. Гэхдээ эрчим хүчний хөнгөлөлттэй тариф, төлбөрийн үр ашиггүй аргачлал зэрэг нь эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх хүсэл эрмэлзлийг бууруулж, ногоон эдийн засаг, эрчим хүчний хэмнэлттэй байшин руу шилжих шилжилтийг удаашруулах гол хүчин зүйл болж байна.

Асуудал нь тодорхой, шийдэл нь тодорхой, боломжтой мэт боловч өргөн хүрээнд, үр дүнтэй хэрэгжүүлэхэд техник, санхүү, эрэлт, чадавхтай холбоотой бэрхшээлүүд тулгарсаар байна. Тухайлбал,

(1) Эрчим хүчний хэмнэлт гаргах хөшүүрэг

дутагдалтай. Эрчим хүчний хөнгөлөлттэй тариф, дулааны хэрэглээний тоолуурын системгүй;

(2) Хуучны угсармал орон сууцанд термостат тохируулга суурилуулахад техникийн шийдэл төвөгтэй, зардал өндөртэй;

(3) Санхүүжилтийн боломж хязгаарлагдмал бөгөөд Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) нь хуулийн статусын хувьд тодорхой бус, зээлийн санхүүжилт авлаа гэхэд барьцаа хөрөнгө дутагдалтай;

(4) Энэ төрлийн арилжааны гэрээ, хэлэлцээр хийх, төслийг хэрэгжүүлэх туршлага, чадавх дутагдалтай.

Энэ чиглэлээр хийгдсэн өмнөх судалгаанууд эрчим хүчний хэмнэлтийн санхүүжилтийг бүрдүүлэхдээ төсвийн хөрөнгө оруулалтыг ашиглан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахыг зөвлөсөн байдаг. Амьдрах орчин нөхцөлөө сайжруулах хүсэлтэй иргэдэд зориулсан орлогод нь нийцсэн амины сууцны эрэлт хэрэгцээ хангагдаагүй, тодорхой шийдэлгүй хэвээр байна. Азийн Хөгжлийн Банкны судалгаагаар гэр хорооллын өрхүүдийн 60% нь худалдан авах чадвартай тохиолдолд амьдрах орчин нөхцөлөө сайжруулах хүсэлтэй гэжээ. Гэрт амьдарч буй эдгээр өрхүүд орлого нь нэмэгдэх боломж бүрдэхэд орон сууцанд шилжин суурьших эсвэл өмчилсөн газартаа амины сууц барьж амьдардаг. Чухам энэхүү замналаар Улаанбаатар хотын өнөөгийн гэр хороолол бий болсон. Харин өнөөдөр иргэд амьдрах орчноо сайжруулах, амины байшин барихдаа эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны талаар мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлага үүсэж байна. Энэ нь иргэдийг хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх нь чухал болж байна.

Гэр хорооллыг барилгажуулах төрийн бодлого, иргэдийн амьдрах орчноо сайжруулах хүсэл сонирхол, хэрэгцээнээс гадна эрчим хүчний хэмнэлтэй барилгыг хөгжүүлэх барилгын салбар болон эрчим хүчний хэмнэлттэй орон сууцыг санхүүжүүлэх банк, санхүүгийн салбарын сонирхол нэмэгдэж, оновчтой шийдэл, хамтын ажиллагааг идэвхтэй эрэлхийлж байна. Ялангуяа, тогтвортой санхүү, ногоон санхүүжилтийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн банкны салбар, түүн дотроо тэргүүлэгч банкууд хувийн хэвшлийг манлайлж, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх санхүүжилтийг нэвтрүүлэн, өргөжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаа нь эрчим

хүчний хэмнэлтийн чиглэлд өргөн боломжийг нээж байгаа юм.

Эрчим хүчний санхүүжилтийг хэрэгжүүлэхийн тулд дараах алхмуудад анхаарч ажиллах нь үр дүнтэй.

Эрчим хүчний үр ашгийн гэрчилгээжүүлэлт. Аливаа хөрөнгийн (хөдлөх, үл хөдлөх) үр ашиг, бүтээмжийн үзүүлэлт, түүний зах зээлийн үнэлгээ, борлуулалтад шууд нөлөөлдөг. Иймд барилгын эрчим хүчний үр ашгийн гэрчилгээжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэх нь эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхэд түлхэц болох юм. Гагцхүү, эрчим хүчний үр ашгийн талаарх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийг нэвтрүүлснээр санхүүжилтийн хөнгөлөлттэй нөхцөл, хүү зэрэг эрчим хүчний үр ашгийн урамшууллын хэрэгслүүдийг амжилттай хэрэгжүүлэх боломж бүрдэх юм. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр “ногоон худалдан авах ажиллагаа”-ны тодорхойлолт тусгаж өгсөн байдаг. Мөн хуулийн 11 дүгээр зүйлд тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох тухай нэмэлт заалт орсон. Гэсэн хэдий ч “ногоон” бараа, ажил, үйлчилгээний тодорхойлолт гараагүй, энэ төрлийн худалдан авах ажиллагаанд үзүүлэх хөнгөлөлт, давуу эрх олгох журам тодорхойгүйгээс хэрэгжихгүй байна. Төсвийн хөрөнгө оруулалтын багагүй хэсэг нь барилгын ажил үйлчилгээ байдаг бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй барилгын зураг, гэрчилгээжүүлэлт энэхүү санаачилгыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Зах зээл ба үр ашиг. Эрчим хүчний үр ашигтай барилга барих нь эцэстээ (төсөл хэрэгжүүлэгч, худалдан авагч зэрэг) талуудад үр ашигтай байх учиртай. Барилгын аливаа төсөл нь олон талын оролцоо, хүчин чармайлт шаарддаг нарийн төвөгтэй горимтой. Иймээс эрчим хүчний үр ашигтай төлөвлөх, гүйцэтгэх, гэрчилгээ авах зэрэг

бүхий л процесс нь нэмэлт шат дамжлага, хүнд суртал, зардал, хугацааг хамгийн бага байлгах үр ашигтай хэлбэрийг эрэлхийлэх нь нэн чухал юм.

Норм, дүрмийн шаардлага нэмэгдэхийн хэрээр барилгын салбарын бүхий л оролцогчдод шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, чиг баримжаа болох хэрэглэхэд хялбар тооцоолуур, бусад хэрэгслийг хөгжүүлэх боломжтой. Энэ нь иргэдийн боловсрол, хөрөнгө оруулалтын итгэл үнэмшлийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Норм, дүрэм, журамд өөрчлөлт оруулснаар барилгын эрчим хүчний үр ашиг (өөрөө) дээшлэхгүй. Эрчим хүчний үр ашигтай барилга төлөвлөх, гүйцэтгэх, хяналт, гэрчилгээжүүлэлт зэрэг бүхий л шатанд эрчим хүчний үр ашгийн мэдлэг, чадвартай мэргэжилтнүүд шаардлагатай. Эдгээр мэргэжилтнүүд эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхэд зөвлөх, хяналт, гэрчилгээжүүлэлтийг зохих хөлс, төлбөртэй гүйцэтгэж шинэ зах зээл, үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай.

Тууштай бөгөөд тогтвортой. Барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ нь гагцхүү өргөн хүрээнд, урт хугацааны туршид хэрэгжих аваас үр дүнтэй. Иймд энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь урт хугацааны туршид тогтвортой, бодлогын чиглэлээс хазайхгүй байх нь нэн чухал юм. Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн арга хэмжээ нь иргэд, байгууллагын зуршил, дадалд өөрчлөлт оруулах шаардлага тулгардаг. Харин дадал, зуршил өөрчлөгдөхөд багагүй хугацаа, мэдлэг, мэдээлэл, тууштай хэрэгжүүлэх учиртай.

Чадавхжуулалт. Барилгын эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийг санхүүжүүлэхэд тухайн салбар, үйл ажиллагаанд оролцож буй талууд, дэд бүтэц цогцоор хөгжих ёстой. Иймээс барилгын эрчим хүчний мэргэжилтнүүд, энэ талаар мэдлэг туршлага бүхий зураг төслийн компани, барилгын төсөвчин, барилгын компаниуд, эргээд хяналт хийх чадвартай мэргэжлийн хяналт, эрчим хүчний аудиторууд, мөн банк, санхүүгийн мэргэжилтнүүдэд энэ талын мэдлэг туршлага олгох нь салбарт тулгараад буй бэрхшээлүүдийг туулж боломжуудыг нээхэд хамгийн эхний алхам болох юм.

МОНГОЛ-ЗӨВЛӨЛТИЙН САНСРЫН ХАМТАРСАН НИСЛЭГИЙН 30 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН ГАРГАСАН ЗООС



Он: 2011 | Нэрлэсэн үнэ: 20 000 төгрөг

Метал: мөнгө 999 | Жин: 1000 гр

НҮҮР ТАЛ: Сансрын нисгэгч В.Жанибеков, Ж.Гүррагчаа нарын хөрөг дээр "Vladimir Dzhanibekov", "Jugderdemid Gurragchaa", дээд талаар нь "1981 - 30th Anniversary of joint flight in space - 2011" гэж англиар бичсэн.

АР ТАЛ: Монголбанкны эмблемний хоёр талд "Монгол", "Улс" гэж монгол бичгээр, доод талд нь мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнийг кирилл үсгээр бичиж, улсын нэр, жин, сорьц, төмөрлөг зэргийг "Mongolia 1000g, 999 silver" гэж англиар бичсэн.

2020 ОНЫ ДОЛООДУГААР САРД

2.2 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2020 оны 7 дугаар сард 2.2 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 13 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5.5 тн-р өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 13 тн үнэт металлын 11.3 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна.

2020 оны 7 дугаар сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 81,7 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 169 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 815.6 кг үнэт металл худалдан авлаа.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 6 дугаар сард 167,504.44 төгрөг байлаа.


Дүрслэл 1. 2018-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)



Дүрслэл 2. 2020 оны 7 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)




Дүрслэл 3. 1990-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)



ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2020/07/31-ний хооронд 2,769.6 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1660 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



Ипотекийн зээлд 45 тэрбум төгрөг хуваарилав

Монголбанк ипотекийн зээлийн хөтөлбөрт оролцогч талуудтай байгуулсан гэрээний дагуу 2020 оны 5 дугаар сард **25 тэрбум** төгрөгийн эх үүсвэр, 6 дугаар сард **20 тэрбум** төгрөгийн эх үүсвэр, нийт **45 тэрбум** төгрөгийн эх үүсвэрийг банкуудад хуваарилсан. Үүний дагуу Монголбанкны эх үүсвэрээр **24.6 тэрбум** төгрөгийг 403 иргэнд, банкуудын өөрийн эх үүсвэрээр **25.9 тэрбум** төгрөгийг 280 иргэнд нийт **50.4 тэрбум** төгрөгийн санхүүжилтийг 683 иргэнд олгоод байна.



А.АНАНД: 73876 ЗЭЭЛДЭГЧ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН БҮТЭЦДЭЭ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛААД БАЙНА

Монголбанкны Мөнгөний бодлогын газрын
Макро зохистой бодлогын хэлтсийн захирал
А.АНАНДТАЙ ярилцлаа.

Монголбанкнаас макро зохистой бодлогын шийдвэрийн хүрээнд цар тахлын үеийн хүндрэлийг даван туулах зорилгоор хэрэглээний зээлийн хугацааг нэг удаа 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргасан. Шийдвэрийн хэрэгжилт, үр дүн ямар байна вэ?

- Санхүүгийн тогтвортой байдалд үүсч болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор хэт өндөр түвшинд хүрээд байсан хэрэглээний

зээлийн өсөлтийг хязгаарлаж, банкнаас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа 60 хувиас хэтрэхгүй байх, зээлийн хугацаа 30 сараас хэтрэхгүй байх гэсэн хязгаарлалтуудыг мөрдөж байгаа. Гэсэн хэдий ч Ковид-19 цар тахлаас шалтгаалан иргэдийн орлого тасалдаж, зээлийн эргэн төлөлтийг хийхэд хүндрэлтэй болж эхэлсэн. Тиймээс дээрх хязгаарлалтууд мөрдөгдөж эхлэхээс өмнө авсан байсан хэрэглээний зээлүүдийн хувьд зээлийн хугацааг сунгаж, бүтцээ өөрчлөх боломжгүй байсан тул Мөнгөний бодлогын хороо хуралдаж, хэрэглээний зээлийн хугацааг нэг удаа 12 хүртэлх сараар, зээлийн үлдэгдлийг нэмэгдүүлэхгүйгээр сунгах боломжийг олгосон. Банкуудаас ирүүлж буй тоон мэдээллийг харвал дөрөв, тавдугаар сард долоо хоногт дунджаар 9200 хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт орж байсан бол зургаадугаар сард энэ тоо 3300 болж буурсан байна. Харин долоодугаар сарын байдлаар долоо хоногт дунджаар 1700 зээлдэгч зээлийн хугацаагаа сунгаж, бүтцээ өөрчилж байна. Нийтдээ 73876 зээлдэгч хэрэглээний зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан байна. Нийт дүн нь 648 тэрбум төгрөг болж байна. Үүний дийлэнх нь цалингийн зээл юм. Ингэснээр бүтэц өөрчлөгдсөн хэрэглээний зээлүүдийн дундаж хугацаа өмнө нь 29.2 сар байсан бол одоогийн байдлаар 35.5 сар болж 6 сараар өссөн байна.

Бизнесийн зээлийн хувьд бүтцийн өөрчлөлт хийх боломжтой байгаа юу?

- Аж ахуйн нэгжүүдийн хувьд зээлийн бүтэц өөрчлөхөд хэрэглээний зээлд мөрдөгддөг шиг хязгаарлалтууд байхгүй тул хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлтийг хуваарьт заасны дагуу төлж чадахгүй нөхцөл байдал үүссэн бол өөрийн үйлчлүүлдэг банканд хандан гэрээндээ нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой.

Олон улсын туршлагаас харвал макро зохистой бодлогын ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна вэ?

- Дэлхийн улс орнуудад макро зохистой бодлогын хүрээнд хэд хэдэн нийтлэг арга хэрэгслүүдийг түгээмэл ашиглаж байна. Тухайлбал, банкны өөрийн хөрөнгийн нөөцийн шаардлагыг сулруулах, хуримтлагдсан нөөц

хөрөнгийг чөлөөлөх, банкуудад тавигдах хөрвөх чадварын нөөцийн шаардлагыг сулруулах нь түгээмэл байна. Ингэхдээ зарим оронд валютын төрлөөс хамааруулан хөрвөх чадварын харьцааны шаардлагыг ялгаатай байдлаар сулруулах зэрэг бодлогын шийдвэрийг гаргасан байна. Түүнчлэн олон орны төв банкуудаас заавал байлгах нөөцийн шаардлагыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Эдгээр арга хэмжээнүүд нь цар тахлын сөрөг нөлөөгөөр санхүүгийн нөхцөл байдал чангарч, зээлийн тасалдал үүсч, санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэл үүссэн энэ цаг үед банкны хөрвөх чадварыг дэмжих, зээл олголтыг аль болох тасалдуулахгүй явуулах гол зорилготой.

Эдгээрээс гадна улс орон болгон өөр өөрсдийн онцлогт тохирсон арга хэмжээг авч байгаа. Тухайлбал, АНУ гэхэд бэлэн мөнгө тарааж байна. Энэ нь иргэдийн наад захын хэрэгцээг хангах, мөнгөн орлогыг тасалдуулахгүй байх зорилготой. Бусад улсын жишээг харахад ч гэсэн, ЖДҮ-д хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хугацааг сунгах зэрэг шийдвэрийг өргөнөөр авч хэрэгжүүлж байгаа.



**МОНГОЛБАНКНЫ ХУВЬД Ч ГЭСЭН
ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ХУГАЦААГ
СУНГАХААС ГАДНА БАНКУУДАД МӨРДӨГДӨЖ
БУЙ АКТИВ АНГИЛАХ ЖУРАМ, БАНКНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ ЗОХИСТОЙ
ХАРЬЦААНЫ ХОЛБОГДОХ ЖУРМУУДАД ТҮР
ХУГАЦААНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ ТУХАЙ БҮР
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЖ БАЙГАА.**



Монголбанкнаас “Ковид-19” цар тахлын хүндрэлийг бууруулах зорилгоор бодлогын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа шүү дээ. Мөнгөний бодлогын хүүг бууруулахаас эхлээд нэлээд олон томоохон шийдвэр авч хэрэгжүүлж байна. Энэ бүх арга хэмжээнээс хүлээх гол үр дүн юу вэ?

- Нөхцөл байдлыг тогтворжуулах үүднээс Засгийн газрын зүгээс аж ахуйн нэгжүүдийг дэмжих, ажлын байрыг хадгалахад чиглэсэн арга хэмжээг авсан бол Монголбанкнаас бодлогын хүүг бууруулж мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, банкны салбарын зохицуулалтыг түр хугацаанд зөөлрүүлэх,

төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах, банк хоорондын захын нөөцийг дэмжих зэрэг шийдвэрүүдийг гаргасан нь банкны салбарын эрсдэлийг бууруулахад зохих хувь нэмэр оруулж байгаа. Эдгээр арга хэмжээ нь банкны системд үүсч болзошгүй аливаа эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй. Цаашид Засгийн газрын зүгээс бизнесийн салбарыг идэвхжүүлэх, эдийн засаг сэргэх үед банкууд зээлийн чадавхтай байх нь туйлын чухал байхаар байна.

“Ковид-19” цар тахлын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл ямар байна вэ, оны эцэст нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөр байна вэ?

- Монгол Улсын хувьд цар тахлын эдийн засагт үзүүлэх анхдагч нөлөө нь төлбөрийн тэнцлийн сувгаар буюу гадаад эрсдэл хэрэгжиж эхэлснээр мэдрэгдэж эхэлсэн. Энэ нь юуны түрүүнд нүүрсний экспорт огцом буурсантай холбоотой. Гадаад секторын нөхцөл байдал эрс муудсанаас болж Монгол улсын эдийн засаг 2020 оны 1 дүгээр улиралд 10.7 хувиар агшсан. Мөн энэ оны 2 дугаар сараас эхлэн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнээр эдийн засгийн дотоод эрсдэлүүд орлогын болон зээлийн сувгаар дамжин хэрэгжиж эхлээд байна. Энэ хугацаанд компаниуд, өрхийн аж ахуйн орлого үлэмж хэмжээгээр буурсан бол төсвийн орлого эхний 6 сарын байдлаар 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан. Зээлдэгчдийн орлого огцом буурснаар банкуудад зээлийн бүтцийг өөрчлөх санал хүсэлт олноор ирж байсан.

Манай улсад бүртгэгдсэн вирусын тохиолдол харьцангуй цөөн байгаа боловч гадаад эрэлтийн огцом бууралт, дотоодын хөл хорионы арга хэмжээ зэргээс шалтгаалж бодит эдийн засгийн өсөлт 2020 онд -1 хувийн орчимд байх төлөвтэй байна. Гадаад өрийн хэмжээ өндөр хэвээр, мөн ойрын хугацаанд барагдуулах гадаад өрийн хуваарь шахуу байгаа нь гадаад валютын нөөцөд ихээхэн дарамт үүсгэж Монгол Улс томоохон гадаад шокийн нөлөөнд тун эмзэг байгаа нь харагдаж байна.

- Ярилцсанд баярлалаа.

ХӨГЖИЖ БУЙ УЛС ОРНУУДЫН ГАДААД ӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



КОВИД-19 цар тахал дэгдсэнээр нэгэнт эмзэг болоод байгаа дэлхий нийтийн эдийн засагт маш их ачаалал өгч цаашлаад өөр өөр асуудлуудыг бий болгоод байна. Тэдгээрийн нэг нь яах аргагүй улс орнуудын өрийн хэмжээ юм. 2008 онд олон улсын санхүүгийн хямрал болсноос хойш дэлхийн эдийн засаг сэргээд байсан ч гадаад өрийн хэмжээ эрчтэй өссөн нь дараачийн хүндрэлийг нөхцөлдүүлэх эрсдэлтэй боллоо. Тиймээс энэ удаагийн дугаартаа улс орнуудын өрийн хэмжээ, цаашид анхаарвал зохих асуудлын талаар нийтлэхээр шийдлээ.


ӨРИЙН ДАВЛАГАА

- ОУВС-ийн судалгаанаас харахад хөгжиж байгаа улс орнууд 1970-2009 оны хооронд өрийн 3 давлагааг туулсан бөгөөд 2009 оны олон улсын санхүүгийн хямралын дараа өмнөх 3 давлагаанаас илүү эрчтэй давлагааг бий болжээ. Өрийн **эхний давлагаа 1970-1989 онд** тохиосон. 1970-аад онд зээлийн зардал бага байсантай зэрэгцэж, Латин Америк болон орлого багатай орнууд синдикат зээлүүдийг их хэмжээгээр авснаар өрийн хэмжээ өссөн. Энэ үед мөн удаа дараагийн санхүүгийн хямралууд болсон ба Дэлхийн банк, ОУВС-

ийн оролцоотой өрийн дарамтад орсон ядуу буурай орнуудад зориулсан Брэдигийн төлөвлөгөө, Өр төлбөрийг арилгах олон талт санаачилга зэрэг зээлийн бүтцэд өөрчлөлт оруулах, чөлөөлөх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.

- Санхүү, хөрөнгийн зах зээлийн либералчлал эхэлснээр Ази, Номхон далайн орнуудын банк, бизнесийн секторт болон Европ, Төв Азийн улсуудын засгийн газруудад илүү их санхүүжилт татах боломж бий болж, өрийн **хоёрдугаар давлагаа 1990-2001 оны** хооронд тохиов. Эдгээр улсууд гадаад валютаар

илэрхийлэгдсэн зээл их хэмжээгээр авсан нь 1997-2001 оны хямралыг давах хөшүүрэг болсон юм. Үүнд мөн Дэлхийн банк, ОУВС-гийн оролцоо их байсан ба хувийн секторт шаардлагатай байсан зээлийг томоохон банк, корпорациудын дэмжлэгтэйгээр хүргэсэн. Цаашлаад өрийн **гуравдугаар давлагаа 2002-2009 онд** болж, Европ, Төв Азийн орнуудын хувийн секторт шаардагдаад байсан зээлийг Европын холбоонд төвтэй мега банкууд олгосноор бий болжээ. Энэ үед төсөв, мөнгөний зөөлөн бодлого давамгайлж байсан ба төгсгөлд нь 2008-2009 оны хямралтай тулгарав.



Өмнө нь дурдсан гурван давлагаанд хэд хэдэн зүй тогтол ажиглагдах ба тэдгээрээс дурдвал; зээлийн хүү бага байхад эхэлж, санхүүгийн шинэ инновациуд буюу зээлийн шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэн ашиглаж, дэлхий нийтийг хамарсан дараагийн хямрал тохиох үед эцэслэж байв. Тухайлбал, 1982, 1991, 2009 оны хямрал 1998, 2001 оны хүндрэлүүд давхцаж байгаа нь хөрөнгө оруулагчдын эрсдэлд мэдрэг байдал, эрсдэлийн өгөөж, зээлийн зардал өсөхийг дагаж, хөрөнгийн урсгал тасалдах, огцом уналт буюу шок бий болсонтой холбоотой юм.

- Санхүүгийн хямралуудыг дагаж эмзэг байдлыг бууруулах реформууд, инновациуд нэвтэрч эхэлсэн нь глобал эдийн засагт хөгжил авчирсан. Жишээлбэл, улс орнууд нөөц хуримтлуулж, валютын ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх, Төв банкууд инфляцыг онилох, Засгийн газар төсвийн

дүрэм баримтлах, санхүүгийн секторын хяналт шалгалтыг чадавхжуулах шаардлагыг бий болгосон. Гэхдээ эхний давлагаа засгийн газрын өрийг нэмэгдүүлсэн бол хоёр, гуравдугаар давлагаа хувийн секторт төвлөрч байснаараа ялгаатай.

ӨРИЙН ДӨРӨВДҮГЭЭР ДАВЛАГАА БА ТҮҮНИЙГ ДАВАХ

- Сүүлийн давлагаа 2010 онд эхэлсэн ба өмнөх 3-аас илүү хүчтэй байж, төр болон хувийн секторын зээлийн хэмжээ зэрэгцэж өссөн. Нэг талаас түүхий эдийн экспортлогч улсуудын хувьд 2014-2015 оны үнийн уналтаас үүдэж Засгийн газрын өр нэмэгдэж эхэлсэн бол нөгөө талаас Санхүүгийн хямралын дараа хэт бага хүүгийн дэглэм ноёрхож, цар тахал дэгдэх хүртэл авах зарах үнийн зөрүү бага байсан нь хувийн секторын зээлийг өрдсөн. Тус давлагааны онцлог нь зээлийн тархац зөвхөн тодорхой бүс нутагт бус илүү далайцтай байсан явдал юм. Хөгжиж байгаа болон хөгжил буурай орнуудын өрийн хэмжээ 2010-2019 оны хооронд дунджаар жилийн ДНБ-ий 7%-аар буюу нийт 60%-тай дүйцэх хэмжээгээр өсч 170%-д хүрсэн байна. Түүнчлэн, энэ удаад зохицуулалт султай банк бус санхүүгийн систем дээр зээл олголт түлхүү төвлөрсөн.
- Хөгжиж байгаа орнуудын хувьд өр их хэмжээгээр хуримтлагдаж ирсэн ч КОВИД-19 дэгдэлт, түүнээс үүдэлтэй санхүү, эдийн засгийн стресс бий болсноор цаашид хэрхэн өрийн удирдлагыг амжилттай хийх вэ гэдэг чухал асуулттай тулгарч байна. Төсвийн болон урсгал дансны алдагдал тэлж, оршин суугч бус хөрөнгө оруулагчдаас гадаад валютын буюу илүү эрсдэлтэй зээл авч байгаа нь нөхцөл байдлыг цаашид улам хүндрүүлэх аюултай. Цар тахал санхүүгийн зах зээлд ноёрхоод байсан тайван байдлыг эвдэж, эдийн засаг, институт, бодлогын чадавхыг бодитоор шалгаж байна.
- Энэ удаагийн хямрал өмнөхөөс ялгаатай нь халдварт өвчнөөс үүдэлтэй гэдгийг бид мэдэх бөгөөд даван туулахын тулд өвчинтэй тэмцэх төсвийн зардал гаргах шаардлагыг бий болгож, улмаар хөгжиж байгаа орнуудын

төсвийн алдагдал 2020 онд 5 орчим хувиар тэлэх төсөөлөлтэй байгааг ОУВС мэдээлэв. Нөгөөтэйгүүр, өрийн давлагаан дээгүүр сурфинг хийж, гадаад болон дотоод шокиг намжаах, даван туулах төрөл бүрийн арга байгаа ба улс орны нөхцөл байдлаас хамаарч сонголт хийн, ашиглаж болно. Тэдгээрийг нийт 4 бүлэг болгож хуваах боломжтой юм.



- **Өрийн зөв удирдлага ба ил тод байдал:** Санхүүжилт татах шаардлага байгаа үед зээл авахаас өөр аргагүй нь үнэн боловч, зөв удирдаж байна уу, зарцуулалт нь ил тод байна уу гэдэг маш чухал. Ирээдүйд төлөх нь тодорхой учир эргэн төлөлтөө хэрхэн хийх вэ гэдгийг анхаарч, тооцоолох нь байх ёстой арга хэмжээ. Төсвийн алдагдлыг Засгийн газрын үнэт цаас хэлбэрээр Төв банкнаас санхүүжүүлэх боломжтой ба энэ үед мөнгөний бодлогын хараат бус байдлыг хангах нь зүйтэй.
- **Сайн засаглал:** Маш том хэмжээний төсвийн дэмжлэгүүд олгогдож байгаа хэдий ч, мөнгийг ухаалаг зарцуулах нь хүн бүрийн анхаарах ёстой асуудал. Өмнөх хямралуудаас харахад хөгжиж буй орнуудын татсан санхүүжилтүүд нь экспортыг нэмэгдүүлэх, бүтээмж болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд төдийлөн дэмжлэг болоогүй нь илэрхий болсон ба урт хугацаанд үр дүн муутай байсан гэсэн үг. Ер нь хямрал тохиолдсон үед нэг талаас санхүүжилт татсан анхны зорилго, түүндээ хүрч байгаа эсэхийг хянаж, шийдвэр гаргалт бүрт зөв засаглалыг хэвшүүлж, дампуурлын зөв бүтцийг тогтоож, зээлдэгч, хөрөнгө оруулагч нарт бүх зүйлийг ойлгомжтой болгох хэрэгтэй. Ингэснээр дараа дараагийн санхүүжилтүүд ч орж ирэх хаалгыг нээх юм.
- **Үр дүнтэй зохицуулалт, хяналт шалгалт:** Санхүүгийн сектор зохицуулалтуудыг хэсэг хугацаанд зөөлрүүлж байгаа хэдий ч хяналт шалгалтыг идэвхтэй үргэлжлүүлж хийснээр бодлого тодорхойлогч нар өөр болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлж, арга хэмжээ авах боломжийг олгох юм. Нөхцөл байдал сайжрах үед хуримтлал нэмэгдэх бөгөөд тэр нь дотоод санхүүжилтийг нэмэгдүүлэх гарц болж өгөх ба түүнийг зүй зохистой чиглүүлж, дэмжвэл зохино.

- **Макро эдийн засгийн хүчтэй бодлого:** Мөнгө, валютын ханш, төсвийн бодлогыг зүй зохистой хэрэгжүүлж маш их эмзэг болоод байгаа глобал эдийн засгийн нөлөөллийг бууруулах нь хөгжиж байгаа орнуудад ашигтай. Уян хатан ханшийн тогтолцоо нь богино хугацаан дахь шокиг зөөлрүүлэх боломжтой ба урт хугацаанд төлбөрийн тэнцэлд үүсч болзошгүй зөрүүг арилгах давуу талтай. Төсвийн хүрээнд орлого, зардалын бодлогодоо тухай бүр тохируулга хийж, хэт өөдрөг төсөөллийг ашиглалгүй, зардлаа эрүүл мэнд, нийгмийн эмзэг бүлэг зэрэг хамгийн шаардлагатай гэсэн зүйлд чиглүүлэх нь зүйтэй. Мөн төсвийн дүрмэнд онцгой нөхцөл байдлын заалтуудыг оруулж болох боловч тэр нь хямралын дараа төсвийн тогтвортой байдлыг нөхөх боломжтой байвал зохино.

Эх сурвалж: A.Kose., F.Ohnsorge., P.Nagle., and N.Sugawara. 2020. Caught by a Cresting Debt Wave. Finance & Development journal, International Monetary Fund (IMF)

International Monetary Fund (IMF). 2020. Fiscal Monitor: Policies to Support People during the COVID-19 Pandemic. Washington, DC, April.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 31/VI ӨДРИЙН БАЙДЛААР)



Б.БАЯРМАА: ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИЛЦАГЧДАА БҮХ ТАЛААР ДЭМЖИН АЖИЛЛАЖ БАЙНА



Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч Б.БАЯРМААТАЙ ярилцлаа.

Худалдаа хөгжлийн банк саяхан Улаанбаатар хотын банктай нэгдсэн. Нэгдсэн хоёр банкны цаашдын үйл ажиллагааны ерөнхий стратеги аль чиглэлд байх талаар ярилцлагаа эхэлье?

Монгол Улсад хоёр шатлалт банкны систем үүсэж, хөгжсөний 30 жилийн ой тохиож буй энэ онд бид томоохон тэлэлтийг хийж, 21 жилийн түүхтэй Улаанбаатар хотын банктай нэгдэж, Монголын банк санхүүгийн салбарт хөгжлийн шинэ шатыг тавьж байна. Энэхүү хүчирхэг нэгдэл нь Монгол Улсын банк санхүүгийн салбарын түүхэнд анх удаа хэвийн үйл ажиллагаатай, банкны секторын нөлөө бүхий хоёр банк нэгдэж байгаагаараа мөн түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал болохыг нэн түрүүнд онцлон хэлмээр байна.

Энэ үйл явдал нь бидний 2019 оноос хойш хэрэгжүүлж буй банкны шинэ стратеги, бүтцэд энэ үйл явдал нь эерэг түлхэц үзүүлж байгааг хэлэхэд таатай байна. Хоёр банкны энэхүү нэгдэл нь харилцагч төвтэй банк байх стратегийн зорилготой нийцсэнээр харилцагчдадаа илүү ойртох, хүртээмжтэй үйлчлэхэд жинтэй хувь нэмэр оруулна. Мөн Олон улсын банк, Платформ банк болох, Дижитал банк байх зэрэг зорилго бүрд бидний баримталж буй стратеги үргэлжилсэн хэвээр байна.

Ийнхүү нэгдсэнээр хоёр банкны харилцагчдад ямар давуу тал, шинэ боломжууд бий болох вэ?

ХХБ-ны хувьд 30 гаруй салбар нэмэгдэж, 1'900 картаар үйлчлэгч байгууллагаар өргөжиж, харилцагчдадаа хүрэх хүртээмж, цар хүрээ улам тэлж буй юм. Мэдээж салбар, АТМ, картаар үйлчлэгч байгууллага нэмэгдэхийн хэрээр харилцагчдад үйлчлэх цар хүрээ илүү өргөн болж байгаа. Мөн хоёр банк нэгдсэнээр "synergy" үүсгэж, бид харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд нийцүүлэх үүднээс бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд илүү дэвшилтэт, таатай нөхцөлтэй болгох олон шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Харилцагчдад үйлчлэх биет салбарын тоо 52%-иар нэмэгдэж, нийт 97 салбартай болсон нь хамгийн том давуу тал юм.

Үүнийг дагаад харилцагчид үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо, төрөл, цар хүрээ нэмэгдсэн.

ХАРИЛЦАГЧ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ХОТ, ОРОН НУТАГ ДАХЬ МАНАЙ БҮХ САЛБАРААС АВАХ БОЛОМЖТОЙ БӨГӨӨД БАНКНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ИЛҮҮ САЙЖИРЧ, САЛБАРУУДЫН БОЛОН АЖИЛТНУУДЫН ТОО НЭМЭГДСЭНЭЭР БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТҮВШИН НЭГ ШАТ АХИСАН ГЭЖ ОЙЛГОЖ БОЛНО.

Бид олон улсын санхүүгийн 150 гаруй байгууллагатай тогтоосон харилцаа, корреспондент банкуудтай ба дотооддоо 17 төрлийн валютаар, олон улсад 44 төрлийн валютаар гуйвуулга хийх боломжийг харилцагчдадаа олгохоос гадна уян хатан, хялбар, илүү таатай нөхцөл бүхий 100 гаруй төрлийн банкны бүтээгдэхүүн үйлчилгээг чадварлаг ажилтнууд болон цахим сувгуудаараа дамжуулан харилцагчдадаа хүргэж байна.

Банкны үйлчилгээний хүртээмж орон нутагт төдийлөн хангалттай биш байгаа. Тэгэхээр системийн ач холбогдолтой хоёр банк нэгдэн нийлж, томорч байгаа учраас орон нутаг дахь үйлчилгээний хүртээмжээ сайжруулахад анхаарч ажиллах байх?

Бид интернэт банкны TDB Online үйлчилгээ, МостМони үйлчилгээгээ тус тус цогцоор нь шинэчилж, TDB Online үйлчилгээний шинэчилсэн хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.

Ингэснээр банкнаас авдаг бүх төрлийн үйлчилгээг цахимаар буюу зайнаас банкны дээр ирэлгүйгээр авах боломжтой болсон.

Мөн ХХБ-ны дижитал стратегийн хүрээнд зөвхөн Монгол Улсаас гадна дэлхийн өнцөг булан бүрд байгаа Монгол иргэддээ банкны үйлчилгээг хүргэх боломжийг 2011 оноос эхлэн үйл ажиллагаандаа шат дараатай нэвтрүүлж, зайнаас харилцах, хадгаламжийн данс нээх, дансаа удирдах бүх боломжийг бүрдүүлсэн байгаа. Тиймээс харилцагч TDB Online банкт байхад орон нутагт ч, алс холын улсад ч байсан банкны хүссэн үйлчилгээгээ авах боломж нээлттэй болсон.

Манай улсын хувьд зарим талаар арилжааны банкуудын тоо их байна гэх шүүмжлэл бий. Банкнууд тооны олноор бус тогтвортой, эрүүл байснаар эдийн засгийн өсөлт, зээлийн хүүг бууруулах зэрэгт чухал нөлөө үзүүлдэг гэдэг. Энэ талаар таны байр суурь юу вэ?

Банк, санхүүгийн салбар өндөр хөгжсөн улс орнуудын практикт томоохон банкуудын нэгдэл нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлээ тэлэх, үнэ цэнээ нэмэгдүүлэх зорилгоор хийгддэг. Ингэснээр нэгдлийн дараах банкуудын ашигт байдал илүү сайжирч, зардал буурч, зах зээл дэх зээлийн хүүгийн түвшнийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар харилцагч иргэд болон байгууллагуудад илүү уян хатан үйлчилгээний нөхцөлийг бий болгох, харилцагч төвтэй бизнес загварыг хөгжүүлэхэд томоохон дэмжлэг болдог.

ХХБ болон УБХБ нэгдсэнээр Монголд өнөөдрийн байдлаар 12 арилжааны банк идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Хэдийгээр зах зээлд арилжааны банкуудын тоо олон байх нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, үнийг бууруулах хүчин зүйл болдог ч хөгжиж буй эдийн засагтай (жигжиг), дотоодын харилцах, хадгаламжийн хэмжээ бага, санхүүгийн зах зээл нь банкны систем дээр голчлон тогтдог манайх шиг улсын хувьд арилжааны банкууд тогтвортой, эрүүл үйл ажиллагаа явуулах нь нэн чухал юм. Нөгөө талаас олон банкууд эх үүсвэрээ нэмэгдүүлэхийн тулд амлаж буй хүүгээ нэмэгдүүлж байгаа төдийгүй цахим банк болон АТМ, Пос, Киоскт өндөр зардал гаргаж байгаа нь зээлийн хүүг дорвитой бууруулахгүй нэг шалтгаан болж байна.

Монгол Улсад 2 шатлалт банкны систем үүссэн 1990-ээд оноос хойш 20-иод арилжааны банк татан буугдсан байдаг. Тэгэхээр арилжааны банкуудын тоо олон байх гэдгээс илүүтэйгээр үйл ажиллагаа нь тогтвортой, хүчирхэг банкнууд оршин тогтнох ёстой гэдэг тал дээр санал нэгтэй байна.

Хоёр банк нэгдэж байгаа учраас мэдээж ажилтнуудынхаа ажлын байрыг хадгалах асуудал чухлаар тавигдах байх. Энэ чиглэлд хэрхэн анхаарч байгаа вэ?

Бид 2019 оноос эхлэн шинэ стратегитайгаа уялдуулж, шинэчилсэн бүтэц рүүгээ шат дараатайгаар шилжиж байгаа. Шинэ бүтцийнхээ дагуу банк өргөжин тэлж, өргөн бүрэлдэхүүнээр үйл ажиллагаагаа явуулах чиглэлийн хүрээнд ажиллаж байна. Эдийн засгийн уналттай, бизнесүүд зогсонги байдалтай байгаа энэ цаг үед ажлын байраа тогтвортойгоор хадгалж, ажилтнуудынхаа нийгмийн баталгааг хариуцлагатайгаар хангаж байгаа нь манай банкны хувьд нийгэм, эдийн засагтаа үзүүлж буй бас нэгэн хувь нэмэр болов уу гэж бодож байна.

Энэ оны хувьд Ковид -19 цар тахлын нөхцөл байдал Монголын эдийн засагт ихээхэн хүнд нөлөө үзүүлсэн жил болж байна. Энэ нөхцөл байдал банканд хэрхэн нөлөөлж байна вэ?

Өмнө нь хэлсэнчлэн бид банкны үйлчилгээг бүрэн цахимжуулах ажлыг шат дараатайгаар бүрдүүлж ажиллаж байгаа тул банкны үйлчилгээ тасалдах, удаашрах, харилцагчдад хүндрэл үүсгэх асуудал гараагүй, харин ч харилцагчдыг заавал банканд ирэлгүйгээр цахимаар төлбөр тооцоогоо гүйцэтгэх, харилцах хадгаламжийн дансаа нээх, түүнийгээ удирдах, захиалсан картаа хүссэн газраа хүргүүлэн авах, хүссэн зээлээ авах зэрэгт түлхэц болох боломжийг бий болгосон гэж харж байна.

Ковид-19 нь улсын эдийн засагт нөлөөлнө гэдэг нь бизнесийн үйл ажиллагаа эрхлэгч, ААНБ, иргэдийн орлогод сөргөөр нөлөөлж буй хэрэг юм. ААНБ, иргэдийн бизнесийн болон цалингийн орлого буурах, тасалдах нь банкны үйл ажиллагаанд шууд буюу зээлийн эргэн төлөлтөөр нөлөөллөө үзүүлж байгаа.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хорио, цээр тавигдсанаар бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа доголдох, зээлээ төлж чадахгүйд хүрэх зэрэг олон хүндрэлүүд бий болж байгаа. Монголбанкны хувьд зээлийн төлбөрийн хугацааг хойшлуулах зэрэг шийдвэрүүд гаргасан. Үүний нөгөө талд харилцагчидтай яг тулж ажиллаж байгаа банкны хувьд харилцагчийг хамгаалах, ойлгох, зөвлөгөө өгөх зэргээр аль болох хамтран ажиллах хэрэгтэй байх. Энэ чиглэлд танай банк хэрхэн ажиллаж байна вэ?

Бид аль болох харилцагчдынхаа үйл ажиллагааг дэмжин, боломжит арга хэмжээнүүдийг тухай бүр нь авч энэ хямралыг хамтдаа давахаар хичээн ажиллаж байна. ХХБ-ны хувьд байгууллагын зээлийн багцын 56.7%, иргэдийн болон SME зээлийн багцын тус бүр 37.2% нь цар тахлын нөлөөнд өртөж болзошгүй зээлийн багц байна.

Хорио цээр эхэлсэн цаг мөчөөс эхлэн бизнес эрхлэгчид, зээлдэгч, харилцагчдын маань хэвийн үйл ажиллагаа доголдож, олон хүндрэлүүд үүссэн учраас ХХБ-ны хувьд тухайн цаг мөчөөс эхлэн харилцагчдынхаа нөхцөл байдлыг харгалзан үзэж, зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах ажлыг шуурхай шийдвэрлэн ажилласан байгаа. Зээлдэгчдийн хувьд бизнес нь доголдож, борлуулалтын орлого буурч байгаа тул харилцагч банкандаа хамгийн түрүүнд зээлийн хугацаагаа сунгах хүсэлтийг ихээр гаргаж байгаа. Бид энэ хүнд үеийг хамтдаа амжилттай даван гарахын тулд харилцагч, зээлдэгчидтэйгээ нягт холбоотой ажиллаж, тэднийг сонсож, зээлийн хугацааг боломжит хэмжээгээр сунгах, эргэн төлөлтийн хуваарийг өөрчлөх, торгуулийн хүү цуцлах, нөхцөлд өөрчлөлт оруулсны шимтгэлээс чөлөөлөх, зээлийн хүү, эх үүсвэргүй баталгааны шимтгэл бууруулах зэргээр тухайн харилцагчийн нөхцөл байдалд тохирсон байдлаар арга хэмжээг авч ажилласаар байна.

Иргэд, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хүндрэл учирч Ковид-19 нөлөөлж байгаа боловч бид эдгээр зээлүүдийн хугацааг сунгах, төлбөрийг хойшлуулах зэргээр идэвхтэй хамтран ажиллаж байна. 2020 оны 7-р сарын 10-ны байдлаар байгууллагын зээлийн багцын 27.7%, SME зээлийн багцын 7.7%, иргэдийн зээлийн багцын 20.1%-д тус тус өөрчлөлт оруулаад байна.

Мэдээж Монголбанкнаас гаргасан шийдвэрүүд болоод банкуудын заавал байх нөөцийн хэмжээг бууруулсан зэрэг нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой алхам байсан.

Цар тахлын эдийн засагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах талаар Төв банк нэлээд олон шийдвэр гаргасан. Энэ шийдвэрүүдийн үр дүнг Та хэрхэн дүгнэж байна вэ?

Монголбанк мөнгөний бодлогын хэрэгслээр дамжуулан шинэ төрлийн Коронавируст халдварын эсрэг хэд хэдэн арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлсэн. Тухайлбал:

Бодлогын хүү болон заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсан нь зээлийн нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх, эдийн засгийн идэвхжилийг дэмжсэн оновчтой шийдвэр болсон.

ҮҮНЭЭС ГАДНА ХҮНДРЭЛД ОРСОН ЗЭЭЛДЭГЧДИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ 12 ХҮРТЭЛХ САРААР СУНГАХ ШИЙДВЭР НЬ ТУХАЙН ЗЭЭЛДЭГЧИЙН ХУВЬД ЗӨВХӨН ХҮНДРЭЛИЙГ ЗӨӨЛЛӨХ БУС АЖ АХУЙН НЭГЖ БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ ШИЙДВЭР БОЛСОН ГЭЖ ДҮГНЭЖ БАЙНА. ИНГЭСНЭЭР НИЙТ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ХЭРЭГЛЭЭ ӨРИЙН ДАРАМТААС ҮҮДЭН ОГЦОМ УНАХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ ӨГЧ БАЙГАА ЮМ.

Мөн зээлийн эргэн төлөлтийн хүндрэлийг бууруулах арга хэмжээнүүдээс гадна хэвийн зээлийн ангилалд хамруулах хугацааг 15 хүртэл хоног байсныг 90 хоног болгож, бүтэц өөрчлөгдсөн зээлийн ангиллыг бууруулан ангилахгүй байх талаар заавар, журамд өөрчлөлт оруулсан нь эргээд банкны үйл ажиллагаанд учирч болох дарамтыг бууруулсан зохистой шийдвэр болсон.

Хэрвээ энэхүү түр өөрчлөлтийг оруулаагүй байсан бол банкууд Төв банкнаас шаарддаг зохистой

харьцааны шалгуур үзүүлэлтээ хангахын тулд зээл олголтоо хумих шаардлагатай болохоор байсан.

Мөнгөний бодлогын хороогоор дээрх шийдвэрүүдийг гаргахаас гадна эдийн засаг дахь долларжилтыг бууруулах, санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор “Ковидоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, бууруулах тухай” түр хууль батлан хэрэгжүүлж байгаа зэргийг дурдах нь зүйтэй болов уу.

– Ярилцсанд баярлалаа.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ЭКСПОРТЫН ЦААШДЫН ТӨЛӨВ

“Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2020

Б.БАТДЭЛГЭР / УИХ-ын Тамгын газрын
МХШҮХ-ийн Төсвийн шинжилгээний
албаны ахлах зөвлөх /

УДИРТГАЛ

Дэлхийн эдийн засгийн өсөлтийг ОУВС-ийн 2019 оны 10 дугаар сарын тоймд 2019-2020 онд 3-3.4 хувьд хүрэх төлөвтэй гэж үзсэн бол дэлхийн банкнаас 2020 оны нэгдүгээр сарын эдийн засгийн тоймд 2019-2020 онд 2.4-2.5 хувьд хүрэхээр тооцоолол, төсөөлөл хийснийг танилцууллаа. Тэд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2019 онд 5.7-6.5 байхаар тооцсон бөгөөд 2020 онд 5.4-5.5 хувьд хүрч буурна хэмээжээ. Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх, тэр дундаа экспортын бүтээгдэхүүний төрөл, хэмжээг нэмэгдүүлэх талаар судалж, ажил хэрэг болгох шаардлагатай байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын 2019 оны тайланд Монгол Улс 141 орноос 102-т эрэмблэгдэж 2018 оноос гурван эрэмбээр доошилсон байна. Тэр дундаа макро эдийн засгийн тогтвортой байдлын үнэлгээгээр 120 дугаарт жагсаж байгааг анхаарч, тогтворгүй байдалд хүргэж буй нөхцөлийг бууруулахад анхаарах хэрэгтэй юм.

ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БҮЙ НААШТАЙ ӨӨРЧЛӨЛТ

2011 онд 17.5 хувь байсан эдийн засгийн өсөлт тасралтгүй буурч 2016 оны эхний 3 дугаар улиралд -1.4 хувьд хүртэл унасан. Харин 2016 оны 3 дугаар улирлаас хойш аажмаар өссөөр 2019 оны жилийн эцсийн байдлаар 5.1 хувьтай боллоо. Энэхүү өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтийн нөлөөгөөр экспортын орлого нэмэгдсэн, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн, үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын өсөлттэй холбоотой байна.

Нэгдсэн төсвийн орлого 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10,801.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1,575.7 тэрбум, төлөвлөгөөнөөс 977.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Тайлант хугацаанд бүх татварын орлогууд төлөвлөснөөс давж биелсэн байна.

Төсвийн орлогын өсөлт, зарлагын хэмнэлтийн нөлөөллөөр нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурлаа. 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн тэнцлийн ДНБ-нд эзлэх хувь -5.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.7 пунктээр буурсан ч 2019 оны -5.8 хувийн алдагдалтай төлөвлөсөн дүнгээс 0.2 пунктээр нэмэгдэж, төсвийн алдагдлын хэмжээ буурсан байна.

Экспорт 2019 оны жилийн эцсийн байдлаар 7,619.8 сая ам.доллар болж 608.0 сая ам.доллар буюу 8.7 хувь, мөн импорт 6,127.4 сая ам.долларт хүрч 252.4 сая ам.доллар буюу 4.3 хувиар өслөө. Импортын өсөлтөөс илүүгээр экспорт нэмэгдсний нөлөөллөөр гадаад худалдааны тэнцлийн ашиг



өмнөх оны мөн үеэс 355.6 сая ам.доллар буюу 31.3 хувиар өсч 1,492.3 сая ам.доллар боллоо. Экспортын өсөлтөд эрдсийн бүтээгдэхүүний экспорт, харин импортод уул уурхайн үйлдвэрлэл, түүнийг дагасан үйлчилгээний өсөлт, ялангуяа машин, механик, тоног төхөөрөмжийн эд анги, бензин, дизель түлшний импорт нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 81.3 хувийг төгрөгийн хадгаламж, валютын хадгаламж, валютын харилцах, үлдэх 18.7 хувийг банкны харилцах, гүйлгээнд гарсан бэлэн мөнгөний өсөлт нөлөөлжээ.

Гадаад валютын албан нөөц өмнөх жилүүдэд тасралтгүй буурч 2016 оны 9 сард 1,092.4 сая ам.долларт хүрсэн хэдий ч 2017 оны эхнээс эргэн өсч 2019 оны 12 сард 4,348.6 сая ам.доллар болсон байна. Энэ нь сүүлийн 12 сарын дунджаар тооцсон импортын 8.9 сарын хэрэгцээг хангах түвшинд болж өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Төлбөрийн тэнцэл 2019 оны 12 сард 188.6 сая ам.долларын ашигтай гарлаа. Үүнд гадаад худалдааны тэнцлийн ашиг, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын орлогын өсөлт голлон нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн зээлийн үйлчилгээний төлбөр 2019 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр

861.0 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 8.0 хувь, нийт зарлагын мөн 7.5 хувийг эзэлж байна.

2019 оны эцэст инфляцийн түвшин 5.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9 пункт, 2017 оны жилийн эцсээс 1.2 пунктээр тус тус буурсан байна. Энэ нь Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл болон Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд тусгасан инфляцийг 8 хувьд барих бодлогоос даруй 2.8 пунктээр буурсан үзүүлэлт юм.

ЭДИЙН ЗАСАГТ ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ

2019 оны жилийн эцсийн байдлаар чанаргүй зээл 40.7 тэрбум төгрөгөөр буюу 2.3 хувиар өсч 1,825.1 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.1 хувийг эзэллээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл буурч байгаа нь сайн боловч чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийг бууруулахгүйгээс банк, санхүүгийн тогтолцоонд эрсдлүүд үүссэн хэвээр байх болно.

Үнэт цаасны арилжаа хумигдаж, гүйлгээ 161.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2.2 дахин буурчээ.

2019 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 8.1 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өссөнийг анхаарч бууруулах шаардлага байна.

Хөрш орны эдийн засгаас хамааралтай, түүхий эдэд суурилсан экспортын бүтэцтэй хэвээр байна.

Манай орны хувьд уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарууд эдийн засгийн өсөлтийн дийлэнхийг ханган, ДНБ-ий өсөлтийн чиг хандлагыг тодорхойлж байна. Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт гэсэн ойлголт байдаг. Үүнийг (Ali, 2007) "Иргэд нийгмийн баялгаас тэгш хүртэх байдал" гэж томъёолсон байна. Дэлхийн банкнаас хүртээмжтэй өсөлт нь ядуурлыг бууруулахын тулд эдийн засгийн өсөлт урт хугацаанд тогтвортой байж, өргөн хүрээг хамрах, энэхүү өсөлт нь тухайн орны ажиллах хүчний ихээхэн хэсгийг хамрах, хөдөлмөрийн багтаамж ихтэй салбарт илүү тулгуурлах шаардлагатай гэж үзсэн болно.

Экспорт, цэвэр экспорт нь Кейнсийн тодорхойлсноор ДНБ-ний нэг бүрэлдэхүүн хэсэг учраас экспортын өсөлт нь ДНБ-ий өсөлт буюу эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлнэ. Экспорт нэмэгдсэнээр гадаад валютын ханшийг бууруулах буюу тогтворжуулах, үйлдвэрлэлд шинэ техник нэвтрүүлэх импортыг дэмжих түлхэц болно.

Дүгнэлт

1. Эдийн засгийн өсөлтийн үед ядуурал тодорхой хэмжээгээр буурч, нэг хүнд ногдох орлого нэмэгдэж байгаа боловч, Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайгаас хэт хамааралтай, эдийн засгийн төрөлжилт сул байна.
2. Судалгаанаас үзэхэд, ДНБ-ий 20 гаруй хувийг бүрдүүлдэг уул уурхайн экспортын орлого эдийн засгийн өсөлттэй хүчтэй, эерэг хамааралтай байгаа бол уул уурхайн бус экспортын орлогын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө маш бага байна.
3. Урт хугацааны эдийн засгийн өсөлтийн тогтвортой өсөлтийг хангах цогц бодлогыг тууштай хэрэгжүүлж, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх нь чухал зорилт болж байна. Хөгжлийн шинэ давуу тал бий болгон, үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлснээр хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг нарийн боловсруулж эрэлттэй эцсийн

бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай байна.

4. Экспортыг дэмжих "Монгол экспорт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгож эрчимжүүлэх, экспортыг дэмжих төсөлд Хөгжлийн банкнаас олгох зээлийн хүүг бууруулах, тоног төхөөрөмжийг лизингээр олгох цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.
5. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох зэс, нүүрс, төмрийн хүдрийг боловсруулалт хийж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж бүрдүүлэн эдийн засгийн өсөлтийг хурдасгах.
6. Экспортын дэд бүтцийг тууштай сайжруулах, эдийн засгийн төрөлжилтийн талаарх судалгааг шинэчилж, нарийвчлан хийх.
7. Уул уурхайн бус экспорт, ялангуяа хөдөө, аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын орлогыг өсгөх шаардлагатай.
8. Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулан, гадаадын жуулчдыг татах аяллын маршрут бий болгож үйлчилгээг сайжруулах, аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдүүлэх хэрэгтэй байна.



ТА ХЭРХЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БОЛОХ ВЭ?

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Хөрөнгө оруулалт гэдэг нь өөрийн нөөцийг ашиглан өнөөдөр худалдан авалт хийснээр ирээдүйд ашиг олох үйл явц юм. Ингэхдээ хөрөнгө оруулагч болохыг сонирхож байгаа хүмүүс зах зээл дээр байгаа төрөл бүрийн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой. Иргэдийн хамгийн сайн мэддэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хадгаламж, хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө зэрэг багтдаг бөгөөд эдгээрээс нэг, эсвэл хэд хэдэн төрлийг сонгох нь тухайн хүний санхүүгийн мэдлэг, хөрөнгө оруулалтын зорилго, эрсдэл даах чадвар зэргээс хамаардаг. Испанийн үргэлжилсэн үгийн нэрт зохиолч Мигель де Сервантес “Нэг сагсанд бүх өндгөө бүү хий” гэж хэлсэн нь нэг хөрөнгө оруулалтын төрөлд бүх мөнгөө оруулах нь эрсдэлтэй болохыг сануулж, өдгөө хөрөнгө оруулалтын алтан дүрэм болжээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт нь ашиг олоход чиглэхээс гадна эрсдэлийн түвшнээ зөв үнэлэн, түүнд таарсан ашгийг олоход оршино. Хэт өндөр ашгийн ард түүнийг олохгүй байх эрсдэл мөн дагалдаж байдаг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЯМАР ЗОРИЛГООР ХИЙХ ВЭ?

Хөрөнгө оруулалтын зорилго нь мөнгөө өсгөн арвижуулах буюу ашиг олоход оршдог. Амжилттай хөрөнгө оруулалт нь богино (1-3 жил), дунд (4-9 жил), урт хугацааны (10 ба түүнээс дээш жил) амьдралын зорилгоо биелүүлэхэд дэмжлэг болно. Ингэхдээ хөрөнгө оруулах сонирхолтой хүмүүсийн амьдралын зорилго нь дараах хэлбэрүүдтэй байж болно. Үүнд:

- Нэгээс гурван жилийн дараа орон сууц худалдан авахад зориулсан урьдчилгаа хөрөнгийг бүрдүүлэх;
- Хүүхдээ 18 нас хүрэхэд их сургуулийн боловсрол олгох, сургалтын төлбөрийг төлөхөд ашиглах;
- Тэтгэвэрт гарсны дараа тасралтгүй орлогоор хангах тэтгэврийн санг бүрдүүлэх;
- Компанийн хувьцаа эзэмшигч болж, шийдвэр гаргах гэх мэт.

ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ХЭРЭГСЛЭЭ СОНГОХЫН ӨМНӨ МЭДЭЖ БАЙХ ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС ЮУ ВЭ?

Аливаа хөрөнгө оруулалтыг хийхийн өмнө мэргэжлийн хөрөнгө оруулагчдын анхааруулдаг хэд хэдэн зүйлс байдаг.

- Санхүүгийн хамгийн энгийн ойлголтуудыг уншиж, судлах;
- Өөрийн хүлээж чадах эрсдэлийн түвшинг тодорхойлох замаар өөрт таарсан хөрөнгө оруулалтын хэрэгсэл, арга техникийг олох;
- Хөрвөх боломжтой хөрөнгө оруулалтуудыг сонгох;
- Мэргэжлийн хүнээс тусламж авах зэргийг санал болгодог.

ИРГЭДЭД ДӨХӨМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЛҮҮД ЮУ БАЙНА ВЭ?

Монгол Улсад хамгийн өргөн хүрээнд хэрэглэгдэж байгаа хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь төгрөгийн хугацаатай хадгаламж байгаа бөгөөд энэ оны 6 сарын байдлаар жигнэсэн дундаж хүү нь 10.98 хувьтай байна. Хөгжингүй орнуудын хувьд энэ нь үнэт цаас байдаг боловч манай орны хувьд бусад улс орнуудтай харьцуулахад хөрөнгийн захын хөгжил тааруу, нээлттэй хувьцаа нь арилжаалагддаг компаниудад хөрөнгө оруулагчдын итгэх итгэл сул зэргээс үүдэн ихэнх хүмүүс өөрийн мөнгөө хадгаламжид хадгалах хандлагатай байдаг. Санхүүгийн зах зээл нь жигд хөгжсөн улс орнуудад мөнгөний захын хөгжилтэй зэрэгцээд систем дэх бусад зах зээлийн хөгжил бий болж байдаг. Иймд иргэдийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна.

МОНГОЛ УЛСАД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

1. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, арилжаа хийх эрхтэй үнэт цаасны компаниудаас байршил, интернет арилжаа зөвшөөрдөг эсэх, шимтгэл, арилжааны түүх, мэдээлэл тогтвортой хангах байдал зэргийг харгалзан өөрт тохирох компанийг сонгох хэрэгтэй.
2. Өөрийн сонгосон үнэт цаасны компани дээр иргэний үнэмлэх, насанд хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээ, банкны дансны дугаар,

дансны хураамжийн хамт очно.

3. Үнэт цаасны компанитай гэрээ байгуулснаар, таны харилцагч компани нь таны нэр дээр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-д данс нээж өгнө. Ингэхдээ таны үнэт цаасны данс 2-3 хоногийн дотор нээгддэг.
4. Ингэснээр та тухайн үнэт цаасны компанийн харилцагч болох бөгөөд цаашид үнэт цаасны компани нь өөрийн эскроу дансаар арилжаа хийнэ. (Эскроу буюу номинал данс – Хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцон үнэт цаас худалдан авах, худалдахад үүсэх хэлцлийн мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэх зориулалт бүхий дансыг хэлнэ. Энэ нь уг үнэт цаасны компани дээр нээгдсэн банкны данс бөгөөд энэхүү дансыг ашиглан арилжаанд оролцох боломжтой)
5. Хувь хүн, байгууллага нь арилжаанд оролцохдоо үнэт цаасны компанидаа хандах бөгөөд ингэхдээ Монголын Хөрөнгийн Биржийн арилжаа 10-13 цагийн хооронд явагдах ба та өөрийн биеэр, эсвэл цахимаар арилжаанд оролцох боломжтой.
6. Арилжааны санал өгснөөс хойш T+1 хугацаа буюу нэг өдрийн дотор өөрийн үнэт цаасны компаниар дамжуулан арилжааны дүнгийн 30 хувьтай тэнцүү хэмжээгээр дэнчин байршуулах ёстой.
7. Арилжааны санал өгснөөс хойш T+2 хугацаа буюу хоёр өдрийн дотор өөрийн үнэт цаасны компаниар дамжуулан арилжааны дүнгийн 70 хувьтай тэнцүү хэмжээгээр дэнчин байршуулах ёстой. Ингэснээр таны арилжаа баталгаажин үнэт цаас дансанд орж ирэх ба хэрэв та энэ хоёр өдөрт хувьцаагаа зарсан бол цэвэр дүнгээр таны дансанд мөнгө орж ирнэ.

УОРРЕН БАФФЕТТЫН ӨГСӨН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛДЭГ ЗӨВЛӨГӨӨНӨӨС:

- Өөрийн мэдлэгийн түвшний хүрээнд хөрөнгө оруулах хэрэгтэй;
- Хувьцаанд хөрөнгө оруулахдаа “value investment” хэлбэрээр урт хугацаанд байршуулах хэрэгтэй;
- Хөрөнгө оруулалтад үнэ болон үнэ цэнэ хоёрыг ялгаж сурах хэрэгтэй;
- Итгэл даахуйц, мэддэг хүндээ л итгэх хэрэгтэй.

ЗАЛИЛАГЧИД БОЛОМЖ БҮҮ ОЛГО



НЯГҖЛАХ тусам
АЮУЛГҮЙ!



WWW.SANKHUUGIINBOLOVSROL.MN